



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

XXXIII ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын XXXIII дугаар хурал 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 01:20 цагт Төрийн ордон дахь Шадар сайдын ажлын өрөөнд 78.1 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар даргалж, холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Монгол Улсад коронавируст халдвар (COVID-19)-ын анхны тохиолдол илэрсэн нөхцөл байдлын талаар Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайханы мэдээллийг сонсов.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Улсын онцгой комиссын гишүүд,

Аймаг, нийслэлийн онцгой комиссын дарга нарт:

1.1. Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тандалт судалгаа хийх зорилгоор нийслэлээс гарах хот хоорондын зорчигч тээвэр болон хувийн тээврийн хэрэгсэл, орон нутгийн хуваарьт нислэг, суудлын галт тэрэгний хөдөлгөөнийг 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 02:00 цагаас 11 дүгээр сарын 13-ны өдрийн 23:00 цаг хүртэл түр зогсоох;

1.2. Нийслэлийн бүх шатны боловсролын байгууллага, сургалтын төвийн үйл ажиллагааг 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 14-ний өдрийг хүртэл түр зогсоох;

1.3. Үүссэн нөхцөл байдлын талаар олон нийтэд мэдээллийн нэг сувгаар буюу зөвхөн Улсын онцгой комисс, Эрүүл мэндийн яамнаас шуурхай мэдээлж байх;

1.4. Үзвэр үйлчилгээний байгууллагууд болон олон нийтийг хамарсан хурал цуглаан, сургалт, спортын тэмцээн уралдаан, соёл урлаг, кинотеатр, цахим болон бага насны хүүхдийн төрөл бүрийн тоглоомын газрын үйл ажиллагааг түр зогсоох;

1.5. Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор хариу арга хэмжээ, бэлэн байдлын төлөвлөгөөг тодотгох, бүх шатны Шуурхай штаб, салбар дундын үйл ажиллагааг эрчимжүүлэх;

Хоёр. Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан,

Тагнуулын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн,
хурандаа П.Одонбаатар,

Цагдаагийн ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн,
цагдаагийн хурандаа Ж.Болд,

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын
гишүүн Т.Гантулга,

Аймаг, нийслэлийн онцгой комиссын дарга нарт:

2.1. Коронавируст халдвар (COVID-19)-аар өвчилсөн иргэнтэй 1, 2 дугаар хавьталтай хүмүүсийг олж тогтоох, тусгаарлалт, хяналтад авах, авах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх;


2.2. Коронавируст халдвар (COVID-19)-аар өвчилсөн иргэний Монгол улс дахь маршрут, үйлчлүүлсэн зочид буудал, худалдаа үйлчилгээ, нийтийн хоол, унаа, ажлын байрыг нарийвчлан тогтоож, холбогдох арга хэмжээг шуурхай авч ажиллах;


2.3. Аймаг, нийслэлийн онцгой комиссын үйл ажиллагааг эрчимжүүлэн коронавирусын цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний төлөвлөгөөг тодотгож, мэргэжлийн ангиудын бэлэн байдлыг хангуулж, холбогдох шаардлагатай арга хэмжээг авч ажиллах;

Гурав. Цагдаагийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Ж.Болд,

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, нийслэлийн
онцгой комиссын дарга Д.Сумъяабазар нарт,

3.1. Улсын онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 12 дугаар тогтоол гарсантай холбогдуулан хот, аймаг, нийслэл, сум, дүүрэг хоорондын хүнсний болон бусад ачаа тээвэрлэлтийг хэвийн явуулах, хүндэтгэн үзэх шалтгааны улмаас (ажлын зайлшгүй шаардлага, хойшлуулшгүй ажил, албан томилот, эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээ, ар гэрийн гачигдал гэх мэт) хот хооронд зорчих төрийн албан хаагч, иргэдийн нотлох баримтыг үндэслэн хүндрэл чирэгдэл учруулахгүйгээр хяналтын цэгээр шалган, нэвтрүүлэх арга хэмжээг тухай бүр авч ажиллахыг тус тус үүрэг болгов.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,
УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА  ЯСОДБААТАР

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ДЭД ХУРАНДАА  Т.МӨНХДОРЖ

УХА0168